

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мэдээлэл, технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/56/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: П.Чанцалдулам Утас: 261815 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn Аудитор: Г.Тэлмүүн Утас: 261815 Цахим хаяг: telmuung@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Эс Жи Эм Ди-Аудит ХХК Захирал: Д.Насанжаргал Утас: 99996948 Цахим хаяг: nasaa@sgmd-audit.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	4
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	10
4. Аудитын тайлан	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
5. Аудитын илрүүлэлт	17
5.1 Төлбөрийн акт	17
5.2 Албан шаардлага.....	17
5.3 Зөвлөмж.....	19
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨТҮГ	Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.16 № 06/700
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Мэдээлэл, технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах залруулагдаагүй 927.2 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал,

- Тайлант онд барагдуулаагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 123.7 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй;
- Дээд шүүхийн 2025 оны 001/ШХТ2025/00940 тоот тогтоолоор Мэдээлэл, технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын гаргасан үндсэн нэхэмжлэхээс 2,329.7 сая төгрөгийг хариуцагч байгууллага (Ньютур сафарис ХХК)-иар төлүүлэхээр, харилцагч байгууллагаас гаргасан сөрөг нэхэмжлэхийн төлбөрт 3,116.9 сая төгрөгийг Мэдээлэл, технологийн үндэсний парк ТӨААТҮГ-төлөхөөр шийдвэрлэснийг бүртгэж, тайлан тэнцэлд тусгаагүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5 дахь заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Компани нь Захирлын 2024 оны А/95 тоот тушаалаар батлагдсан Танхим ашиглах журам"-ын дагуу өөрийн байрны зарим өрөөнүүдийг бусдад цагаар ашиглуулан 102.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Салбарын хамгийн сүүлийн үеийн чиг хандлага, инновацын шийдэл, гарааны бизнесийн санаачилгуудыг танилцуулдаг олон улсын түвшний Tech week-2025 цогц арга хэмжээг зохион байгуулахад Нийслэлийн Засаг даргын тамгийн газар, ТЭСО инвестмэнт ХХК, Мобиком ХХК, Жимобайл ХХК зэрэг ивээн тэтгэгчдээс 197.2 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, 191.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Төрийн аудитын байгууллага нь АДБОУ-ын стандартын дагуу аудитын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

Тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Мэдээлэл, технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,309,442.80	43,243,793.84
1.1.2	Дансны авлага	268,840,774.82	288,542,082.39
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	20,066,943.53	6,336,721.46
1.1.4	Бусад авлага	74,904,485.00	28,612,438.00
1.1.6	Бараа материал	121,302,505.61	117,835,989.87
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/Тооцоо	149,229.00	4,177,976.94
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	486,573,360.76	488,749,302.50
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	4,519,305,579.14	4,686,663,843.75
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,519,305,579.14	4,738,463,843.75
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	5,005,878,939.90	5,227,213,146.25
2	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	37,170,810.00	79,478,898.51
2.1.1.2	Цалингийн өглөг	694,510.00	-
2.1.1.3	Татварын өр	32,599,164.51	108,813,117.56
2.1.1.4	НДШ-ийн өглөг	13,473,152.51	34,935,948.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	340,426,067.51	364,036,373.44
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	16,089,832.33	26,677,552.55
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	440,453,536.86	613,941,890.06
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	2,330,388.15	591,410.07
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	2,330,388.15	591,410.07
2.2	Өр төлбөрийн нийт дүн	442,783,925.01	614,533,300.13
2.3	Эзэмшигчийн өмч		
2.3.1	Өмч: -төрийн	1,021,630,200.00	1,021,630,200.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,042,193,559.47	3,042,193,559.47
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	1,881,956,742.72	1,881,956,742.72
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(1,382,685,487.29)	(1,333,100,656.06)
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	4,563,095,014.89	4,612,679,846.12
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	5,005,878,939.90	5,227,213,146.25

Мэдээлэл, технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,339,424,984.61	1,272,733,314.36
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	(27,855,380.43)	(43,015,176.06)
3	Нийт ашиг (алдагдал)	1,311,569,604.18	1,241,766,138.29
4	Түрээсийн орлого	-	8,692,548.18
5	Хүүгийн орлого	-	10,029.20
6	Бусад орлого	1,172,919,107.22	1,269,156,894.07
7	Борлуулалт, маркетингийн зардал	146,498,496.89	34,881,700.63
8	Ерөнхий ба удирдлагын зардал	2,245,590,362.28	2,268,483,689.95
9	Санхүүгийн зардал	-	-
10	Бусад зардал	-	103,381,206.68
11	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(926,344.40)	-
12	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
13	Биет бус хөрөнгө дансаас хассаны олз (гарз)	-	-
14	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
15	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	91,473,507.83	100,831,012.49
19	Орлогын татварын зардал	9,147,350.78	10,083,101.25
20	Татварын дараах ашиг (алдагдал)	82,236,157.05	90,747,911.24
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг алдагдал	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	82,236,157.05	90,747,911.24
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
24	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	-	-
25	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
26	Бусад олз (гарз)	-	-
27	Орлогын нийт дүн	82,236,157.05	90,747,911.24

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээ	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,021,630,200.00	3,042,193,559.47	789,494,381.42	(1,451,164,820.43)	3,402,153,320.46
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	(13,846,823.91)	(13,846,823.91)
Залруулсан үлдэгдэл	1,021,630,200.00	3,042,193,559.47	789,494,381.42	(1,465,011,644.34)	3,388,306,496.55
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	82,326,157.05	82,326,157.05
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	1,092,462,361.30	-	1,092,462,361.30
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,021,630,200.00	3,042,193,559.47	1,881,956,742.72	(1,382,685,487.29)	4,563,095,014.89
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	(41,163,080.00)	(41,163,080.00)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,021,630,200.00	3,042,193,559.47	1,881,956,742.72	(1,423,848,567.29)	4,521,931,934.89
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний есөлт бууралт	-	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	-	90,747,911.23	90,747,911.23
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,021,630,200.00	3,042,193,559.47	1,881,956,742.72	(1,333,100,656.06)	4,612,679,846.12

Мэдээлэл, технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,120,501,327.19	2,123,935,492.1
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,218,961,655.97	1,476,424,181.4
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	1,182,079.00	105,098.00
	Бусад мөнгөн орлого	900,357,592.22	647,406,212.63
1.2	Мөнгөн зарлага (-)	2,108,364,462.16	2,018,225,556.05
	Ажиллагчдад төлсөн	730,240,484.00	935,984,203.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	212,131,159.75	237,305,000.33
	Бараа материал худалдан авахад төлсөн	81,807,614.00	65,223,442.10
	Ашиглалтын зардалд төлсөн	159,050,742.00	166,677,010.52
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	8,234,000.00	10,180,000.00
	Татварын байгууллагад төлсөн	255,164,374.96	194,782,284.43
	Даатгалын төлбөрт төлсөн	1,721,179.00	-
	Бусад мөнгөн зарлага	660,014,908.45	408,073,284.67
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	12,136,865.57	105,709,936.06
2	Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	26,856,549.57	3,345,964.70
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Бусад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	26,856,549.57	3,335,935.50
	Хүлээн авсан хүүний орлого	-	10,029.20
2.2	Мөнгөн зарлага (-)	48,789,882.07	25,292,881.07
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	18,901,342.00	-
	Бусад олгосон үзэл болон урьдчилгаа	29,888,540.07	25,292,881.07
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(21,933,332.50)	(21,946,916.38)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	16,267,800.00	1,884,431.35
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	16,267,800.00	1,884,431.35
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.2	Мөнгөн зарлага (-)	8,545,043.55	43,713,080.00
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	8,545,043.55	2,550,000.00
	Төлсөн ногдол ашиг	-	41,163,080.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	7,722,756.45	(41,828,648.65)
3.4	Валютын ханшийн зөрүү	-	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(2,073,711.02)	41,934,371.04
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,383,133.82	1,309,422.80
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,309,422.80	43,243,793.84

Мэдээлэл, технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Х/н	2024 оны гүйцэтгэл	2025 он		Харьцуулалт			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйц/ 2025 гүйц	Хувь	2025 төл/ 2025 гүйцэт	Хувь
Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:									
1	Түрээсийн орлого	м.төг	1,258,090.8	1,212,153.3	1,199,911.5	(58,179.3)	95.4	(12,241.8)	99.0
	Бусад орлого/Экспо,И-Монгол академиас хүлээн авах барилгын засвар, лифтболон бусад/	м.төг	237,653.3	282,999.0	282,999.0	45,345.7	119.1	-	100.0
	АСПА 2024 зохион байгуулах орлого	м.төг	65,101.0	-	-	-	-	-	-
	Tech week 2025	м.төг	-	200,000.0	200,000.0	-	-	-	100.0
	Сургалт, шалгалтын орлого	м.төг	358,673.8	310,311.5	204,771.6	-	57.1	(105,539.9)	66.0
	Захиалгат болон зөвлөх үйлчилгээний орлого	м.төг	-	-	-	-	-	-	-
	Инкубаторын үйл ажиллагааны орлого	м.төг	191,271.9	260,343.7	102,882.9	(88,389.0)	53.8	(157,460.8)	39.5
	"Эко систем" хөтөлбөрийн орлого	м.төг	228,924.8	251,583.8	106,961.3	(121,963.5)	46.7	(144,622.5)	42.5
	Хандив тусламжийн орлого	м.төг	298,535.1	265,200.0	207,122.7	(91,412.4)	69.4	(58,077.3)	78.1
	Туслах үйл ажиллагааны орлого	м.төг	60,165.8	265,318.3	159,822.8	99,657.0	265.6	(105,495.5)	60.2
	Хөрөнгийн орлого	м.төг	-	-	634,320.0	694,032.3	-	694,032.3	-
2	Нийт орлого	м.төг	2,698,416.5	3,047,909.5	3,098,791.8	400,375.4	114.8	50,882.3	101.7
3	Нийт зардал	м.төг	2,606,942.5	3,029,499.5	2,963,079.1	356,136.6	113.7	(66,420.4)	97.8
	Үүнээс: Удирдлагын зардал	м.төг	242,332.7	312,884.1	312,884.1	70,551.4	129.1	0.0	100.0
4	Татварын өмнөх ашиг	м.төг	91,474.0	18,410.0	135,712.7	44,238.7	148.4	117,302.7	737.2
5	Цэвэр ашиг /алдагдал/	м.төг	82,326.7	17,160.4	122,141.4	39,814.7	148.4	104,981.1	711.8
6	Төсвийн төлбөрт нийт дүн	м.төг	512,084.5	759,647.1	681,551.0	169,466.5	133.1	(78,096.1)	89.7

Мэдээлэл, технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

№	Үзүүлэлт	Х/н	2024 оны гүйцэтгэл	2025 он		Харьцуулалт			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйц/ 2025 гүйц	Хувь	2025 төл/ 2025 гүйцэт	Хувь
	а/ Орлогын татварт	м.төг	-	1,249.7	1,249.7	1,249.7	-	-	100.0
	б/ НӨТ	м.төг	136,574.7	250,573.5	250,350.0	113,775.3	183.3	(223.5)	99.9
	в/ НДШ	м.төг	195,227.0	344,276.2	237,908.4	42,681.4	121.9	(106,367.7)	69.1
	г/ Хүн амын орлогын татвар	м.төг	70,559.8	87,334.0	74,750.0	4,190.2	105.9	(12,584.0)	85.6
	д/ Үл хөдлөх хөрөнгийн татвар	м.төг	44,250.0	44,250.0	44,250.0	-	100.0	-	100.0
	з/ Тээврийн хэрэгслийн татвар	м.төг	68.9	68.9	68.9	-	100.0	-	100.0
	ж/ Бусад татварт (улсын тэмдэгтийн хураамж)	м.төг	47,670.0	26,308.8	26,308.8	(21,361.2)	55.2	-	100.0
7	Төрийн өмчийн ногдол ашгийн өглөг	м.төг	6,248.5	6,757.1	41,163.1	34,914.6	658.8	34,406.0	609.2
8	Нийт ажиллагсдын тоо	хүн	39.0	43.0	42.0	3.0	107.7	(1.0)	97.7
9	Нийт цалингийн сан	м.төг	800,395.9	1,097,853.5	1,120,657.5	320,261.6	140.0	22,804.0	102.1
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	м.төг	1,755.3	1,721.8	2,223.5	468.2	126.7	501.7	129.1
11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	м.төг	1.0	0.4	0.5	(0.5)	51.0	0.1	115.9
12	Хөрөнгө оруулалт	м.төг	59,351.5	209,840.5	209,750.0	150,398.5	353.4	(90.5)	100.0
13	Нийт авлага	м.төг	363,812.2	268,840.8	323,491.5	(94,971.4)	73.9	-	100.0
	Үүнээс: Найдваргүй	м.төг	-	-	-	-	-	-	-
14	Нийт өглөг	м.төг	442,783.9	433,130.7	614,533.3	148,139.1	138.8	181,402.6	141.9
	Богино хугацаат өр төлбөр	м.төг	100,027.4	48,270.3	249,905.5	149,878.1	249.8	201,635.2	517.7
	УОО /хандив/	м.төг	340,426.1	265,318.3	364,036.4	23,610.3	106.9	98,718.1	137.2
	Урт хугацаат өр төлбөр	м.төг	2,330.4	1,779.7	591.4	(1,739.0)	25.4	(1,188.3)	33.2

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Төрийн өмчийн үйлдвэрийн газар, түүний үйл ажиллагаа

Мэдээлэл, технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын зорилго нь төр, хувийн хэвшил, эрдэм шинжилгээний байгууллагын хамтын ажиллагаанд суурилсан инновацийн тогтолцоог хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах өрсөлдөх чадвар бүхий үндэсний компаниудыг төлөвшүүлэх, мэдээллийн технологийн өндөр ур чадвартай боловсон хүчнийг хөгжүүлэхэд оршино.

Тус үйлдвэрийн газар нь дээрх зорилтын хүрээнд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Харилцаа холбооны дэвшилтэт технологийг хөгжүүлэхэд чиглэсэн бодлогын болон инновацийн судалгаа хөгжүүлэлт хийх;
- Салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан төсөл хөтөлбөрийн бодлогын судалгаа, техник эдийн засгийн урьдчилсан судалгаа, техник эдийг засгийн үндэслэлийг боловсруулах;
- Харилцаа холбоо, мэдээллийн технологи, сансрын технологи, өргөн нэвтрүүлэг, шуудан, мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр суурь, харьцуулсан, хавсарга судалгааг хийх;
- Харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэвшилтэт технологийн төлөв байдал, хандлага, хэрэгцээ шаардлагын судлах, нутагшуулах санал, зөвлөмж боловсруулах;
- Инновацийн үйл ажиллагаа, гарааны бизнесийг дэмжих;
- Үйлдвэрийн газар нь тодорхой мэргэжил, тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг явуулахад холбогдох эрх бүхий байгууллагаас зохих зөвшөөрөл авч, улсын бүртгэлд бүртгүүлснээр тухайн үйл ажиллагааг эрхэлнэ.

Мэдээлэл, технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын дүрэмд зааснаар өмчийг 100 хувь төр эзэмшиж байгаа бөгөөд төрийн өмчийн төлөөллийг Засгийн газраас эрх олгосон төрийн захиргааны байгууллага болох Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар хэрэгжүүлэхээр заасан байна.

3.2 Төрийн өмчийн үйлдвэрийн газрын гадаад, дотоод орчин

Үйлдвэрийн газрын үйл ажиллагааг явуулахдаа Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Монгол улсын иргэний хууль, Инновацийн тухай хууль, Технологи дамжуулах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрддөг дараах хууль, тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт
- Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийн ажиллах журам
- Виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдэд татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх журам
- Монгол Улсын Засгийн газрын баталсан 2025 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 2 дугаар тогтоол.

Мэдээлэл, технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил хэрэгжүүлэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудитын ажилтан нь ерөнхий захирлаар батлуулсан дотоод хяналт шалгалтын 3 удаагийн удирдамжийн дагуу байгууллагын захиргаа хөрөнгө оруулалт, хууль эрх зүй, виртуал бүсийн үйл ажиллагааны хэлтсүүдэд нэгжийн үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн явц, холбогдох хууль, журмын мөрдөлтийн байдалд үнэлгээ өгөх хяналт шинжилгээ хийж, хэрэгжилтийг 75.2 хувьтай гэж үнэлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мэдээлэл, технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Гүйцэтгэх захирлын 2019 оны 1а-02 дугаар тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Мэдээлэл, технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дугаар тушаалаар баталсан аж ахуй нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 240.5 сая төгрөгөөр буюу 4.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,309.4	43,106.2	41,796.8
Авлага	363,812.2	323,491.5	(40,320.7)
Бараа материал	121,302.5	117,973.6	(3,328.9)
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	149.2	4,178.0	4,028.8
Үндсэн хөрөнгө	4,519,305.6	4,738,463.8	219,158.2
Нийт хөрөнгө	5,005,878.9	5,227,213.1	221,334.2
Өр төлбөр	442,783.9	614,533.3	171,749.4
Эздийн өмч	4,563,095.0	4,612,679.8	49,584.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,005,878.9	5,246,399.1	221,334.2

Тайлант онд нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данстууд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 43.1 сая төгрөг болж, 41.8 сая төгрөгөөр өссөн нь үйл ажиллагааны орлого нэмэгдсэнтэй холбоотой;
- Авлагын дансны үлдэгдэл 323.5 сая төгрөг болж, 40.3 сая төгрөгөөр буурсан нь дансны авлага 19.7 сая төгрөгөөр нэмэгдэж, бусад авлага 46.3 сая төгрөг, татвар, НДШ-ийн авлага 13.8 сая төгрөгөөр тус тус буурснаас голлон нөлөөлсөн;
- Бараа материал дансны үлдэгдэл 118.0 сая төгрөг болж, 3.3 сая төгрөгөөр буурсан нь 61.3 сая төгрөгийн худалдан авалтаар нэмэгдэж, 64.6 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулсантай холбоотой;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,738.5 сая төгрөг болж, 219.3 сая төгрөгөөр буурсан нь ТӨБЗГ-ын 2025 оны 402 дугаар тогтоолоор 73.0 сая төгрөгийн хөрөнгийг акталсан, тайлант хугацааны 386.4 сая төгрөгийн элэгдлийн зардлаас голлон нөлөөлсөн. Мөн 678.6 сая төгрөгийн барилга, тоног төхөөрөмж, бусад хөрөнгөөр нэмэгдсэн;
- Өр төлбөр дансны үлдэгдэл 614.5 сая төгрөг болж, 171.7 сая төгрөгөөр өссөн нь дансны өглөг 42.3 сая төгрөг, татвар, НДШ-ийн өглөг 97.6 сая төгрөг, бусад богино хугацаат өр 10.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой;
- Цэвэр хөрөнгө/ өмчийн дансны үлдэгдэл 4,612.7 сая төгрөг болж, 49.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Мэдээлэл, технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

ТӨБЗГ-ын 2024 оны 721 дүгээр тогтоолоор 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд нийт орлогыг 3,639.6 сая төгрөг, нийт зардлыг 3,624.5 сая төгрөгөөр төлөвлөж, 15.1 сая төгрөгийн ашигтай ажиллахаар баталсан байна.

Тайлант жилийн дундуур ТӨБЗГ-ын 2025 оны 506 дугаар тогтоолоор эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний үзүүлэлтүүдэд тодотгол хийж, нийт орлогыг 3,047.9 сая төгрөг, зардлыг 3,029.5 сая төгрөг буюу 18.1 сая төгрөгийн ашигтай ажиллахаар баталсан байна.

Гүйцэтгэлээр 3,098.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 2,963.1 сая төгрөгийн зардал гарган, 135.7 сая төгрөгийн татварын өмнөх ашиг, 122.1 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 3,098.8 сая төгрөг болж, төлөвлөснөөс 50.9 сая төгрөгөөр буюу 101.6 хувиар давж биелсэн байна. Энэ нь тайлант онд түрээсийн орлого 19.9 сая төгрөг, бусад орлого 31.0 сая төгрөгөөр давж биелсэнтэй холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл 2,963.1 сая төгрөг болж, төлөвлөснөөс 66.4 сая төгрөгөөр буюу 2.2 хувиар дутуу зарцуулсан нь удирдлагын зардлыг 28.4 сая төгрөг, бусад зардлыг 38.0 сая төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Тайлант хугацаанд ашигт ажиллагаа сайжирч, татварын өмнөх ашиг 135.7 сая төгрөгт хүрч, төлөвлөснөөс 117.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүний үр дүнд орлогын албан татвар 12.2 сая төгрөг болж, төлөвлөснөөс 10.5 төгрөгөөр өссөн.

Цэвэр ашиг 122.1 сая төгрөг болж, төлөвлөснөөс 105.0 сая төгрөг, төрийн өмчийн ногдол ашиг 61.0 сая төгрөг болж, төлөвлөснөөс 54.3 сая төгрөгөөр тус тус нэмэгджээ.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас судалгаа авч, үр дүнг тусгалаа. Үүнд:

1. **Байгууллагуудын орон тооны цомхотголын талаар:**ТӨБЗГ-ын 2024 оны 721 дүгээр тогтоолын компанийн бүтэц орон тоог 55 ажилтнаар баталсан бол 2025 оны 506 дугаар тогтоолоор 43 ажилтан болгож бууруулсан;
2. **Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын тарифын талаар:** Компанийн захирлын 2024 оны 9 дүгээр сарын 3-ны өдрийн А/67 тоот тушаалаар ажилтан албан хаагчдад олгох 1 өдрийн хоолны мөнгийг 10,000.00 төгрөгөөр тогтсоон, тайланд онд 138.3 сая төгрөг төлөвлөснөөс 91.6 сая төгрөг олгосон;
3. **Гадаад томилолт, арга хэмжээний судалгааны талаар:** Мэдээлэл технологийн салбарын сургалт, арга хэмжээтэй холбоотойгоор гадаад томилолтын 2 арга хэмжэний зардалд 11.0 сая төгрөгийг зарцуулсан;
4. **Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний судалгааны талаар:** Технологийн салбарын хамгийн сүүлийн үеийн чиг хандлага, инновацын шийдэл, гарааны бизнесийн санаачилгуудыг танилцуулдаг олон улсын түвшний Tech week-2025 цогц арга хэмжээг Нийслэлийн Засаг даргын тамгийн газар, ТЭСО инвестмэнт ХХК, Мобиком ХХК, Жимобайл ХХК зэрэг компаниуд 197.2 сая төгрөгөөр ивээн тэтгэн зохион байгуулж, 191.0 сая төгрөгийн зарцуулсан;
5. **Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, төлбөрийн судалгааны талаар:** Тайлант онд Tech week-2025 арга хэмжээний үеэр Ган үзэгтэн ХХК (Зариг.мн), Монголиан модерн контент ХХК (Туг.мн), Монголын Цахилгаан мэдээ агентлаг, Цахиурын дуу хоолой ХХК (Цахиур.мн), Зөв мэдээлэл ХХК (Зөв.мн) зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагуудтай 33.5 сая төгрөгийн гэрээ байгуулан хамтран ажилласан байна.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Мэдээлэл, технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн үйлдвэрийн газар, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн шалгагдагч байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Эс Жи Эм Ди Аудит ХХК-ийн аудитын менежер Б.Оюунцэцэг, ахлах аудитор М.Бямбажаргал, аудитын шинжээч Ч.Ням-Очир, аудитор О.Ганчимэг нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер О.Алтанцэцэг, захирал Д.Насанжаргал нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын аудитор Г.Тэлмүүн, аудитын менежер П.Чанцалдулам, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Мэдээлэл, технологийн үндэсний парк ТӨААТҮГ нь 2025 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 09-ны өдрийн 01/35 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийг сонгож, 1.0 хувиар буюу 50.1 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлж, бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг хэмнэж, байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас, худалдан аваагүй, хэвлэл захиалаагүй, бараа материалыг их хэмжээгээр бэлтгэн нөөцлөөгүй, байгууллагаас хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгоогүй, сургалт, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулах арга хэмжээг авч ажилласан байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон контент хийлгэхэд 3.8 сая төгрөг зарцуулсан асуудалд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар илэрсэн 198.1 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Илрүүлэлт 1: Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 1,210.8 сая төгрөгийн 70 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн, 93.3 сая төгрөгийн орлогын 6 гүйлгээ, 104.7 сая төгрөгийн зарлагын 8 гүйлгээг тус тус мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т "Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна", 3.1.1-т "төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд", 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн заалттай нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх мэдээллийг хугацаанд нь иж бүрэн мэдээлж байх зөвлөмж өгсөн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, бараа материал, үндсэн хөрөнгө, зардал, борлуулалтын орлого данстын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Завсрын аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулан 1,041.2 сая төгрөгийн 4 алдааг залруулж, 2.4 сая төгрөгийн 1 албан шаардлага, 6.0 сая төгрөгийн 1 зөвлөмжийг жилийн эцсийн аудитын дүнд нэгтгэсэн болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон улсын төсөвт төвлөрүүлэх 0.4 сая төгрөгийн 1 төлбөрийн актыг барагдуулж, зөрчлийг арилгах 2.4 сая төгрөгийн 1 албан шаардлага, 1.4 сая төгрөгийн 3 зөвлөмж өгснийг 100.0 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	438.9	1	438.9	100.0

Мэдээлэл, технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Албан шаардлага	1	2,445.2	1	2,445.2	100.0
Зөвлөмж	3	1,427.7	3	1,427.7	100.0
Нийт дүн	5	4,311.8	5	4,311.8	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар худалдан авалт, түрээсийн орлоготой холбоотой гэрээний хэрэгжилт, урьдчилж орсон орлого дансны үлдэгдэлд горим сорил хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 75.7 сая төгрөгийн 3 алдаа алдаа¹ илэрснийг аудитын явцад бүрэн залруулсан.

Залруулсан алдаа:

- Өмнөх онуудад үүссэн авлагыг бартераар буюу 20.0 сая төгрөгийн бараа материалиар барагдуулсныг орлогоор бүртгэж тайлагнасан;
- Бараа материалын дэлгэрэнгүй тайлангийн үлдэгдэл нь санхүү байдлын тайлангийн бараа материалын үлдэгдэл дүнгээс 2.9 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн;
- Харилцагч байгууллагаас авах авлагыг 52.8 сая төгрөгийн хөрөнгөөр барагдуулсныг эрх бүхий байгууллагаас үндсэн хөрөнгөөр бүртгэх зөвшөөрөл олгосон боловч бүртгэл тайланд тусгаагүй байна.

Дээрх алдаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 6.1-т “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэж заасантай нийцэхгүй, Санхүүгийн тайлагналын “үнэлгээ ба хувиарлалт”, “эрх ба үүрэг”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 977.3 сая төгрөгийн 8 зөрчил¹ илэрсэнд, 2.6 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг таслан зогсоож, давтан гарахгүй байх 137.5 сая төгрөгийн 5 албан шаардлага хүргүүлж, 837.2 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 977.3 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 927.2 сая төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт 1: Нэр бүхий 2 ажилтанд цалин болон ээлжийн амралтын хоногийг давхардуулж 2.6 сая төгрөгийн цалинг илүү бодож олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасантай тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх **төлбөрийн акт** тогтоов.

5.2 Албан шаардлага

Илрүүлэлт 1: Өмнөх онуудад үүссэн тайлант онд барагдуулаагүй 123.7 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй, үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг арилгах **албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 2: Тайлант онд компанийн дотоод хэрэгцээнд зарцуулсан бараа материалын шаардах хуудсыг захирал хянан баталгаажуулж гарын үсэг зураагүй, 3.9 сая төгрөгийн бараа материалыг шаардах хуудас бичилгүй зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материалын зарцуулалтанд тавих хяналт сул, анхан шатны баримтгүйгээр бараа материал зарлагадсан зөрчлийг таслан зогсоох **албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 3: Тайлант оны эд хөрөнгийн тооллогын үр дүнг тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй, агуулахад байгаа бараа материалын тооллого хийгдсэн эсэх нь тодорхой бус, тооллогын тохируулгын тайлан хийгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө, үнэт цаас, мөнгөн хөрөнгийн тооллогыг дотоодын тооллого, улсын тооллого гэж хоёр хуваана.", 2-т "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана:", 2 дугаар хэсгийн 1-д "үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жилд нэг удаа /12 дугаар сарын 01-нээс 31-ний дотор/", 72 дугаар зүйлийн 4-т "Тооллогын комисс дараахь үүрэгтэй:", 4 дүгээр хэсгийн 1-д "эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй, иж бүрэн, үнэн зөв хийж, үр дүнг баталгаажуулаагүй зөрчлийг таслан зогсоох **албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 4: Нийслэлийн "Замын хөдөлгөөний удирдлагын төв" ОНӨТҮГ нь тус паркийн 15 машины зогсоолын төлбөрийн орлогын 40 хувийг төвлөрүүлэх гэрээ байгуулсан, төлбөрийг гэрээний дагуу төвлөрүүлээгүй, хоорондын тооцоо үүсгэж бүртгээгүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", "Тээврийн хэрэгслийн төлбөртэй зогсоолын үйл ажиллагаа эрхлэн явуулах гэрээ"-ний 2.4.12-

т "төлбөртэй зогсоолын орлогыг тухайн сар бүрийн 25-ны өдөр Нийслэлийн төрийн сан банкны ЗХУТ. Авто зогсоолын төлбөрийн орлогын 100200000990 тоот дансанд шилжүүлэх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийг төвлөрүүлээгүй, хоорондын тооцоо үүсгэж бүртгээгүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгах **албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 5: "JCI ASPAC-2025" олон улсын арга хэмжээнд зориулж виртуал аватар бүхий контентийг 3.8 сая төгрөгөөр хийлгэж, тайлант хугацааны зардлаар бүртгэж тайлагнасан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4-т "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, үр ашиггүй зарцуулалт гаргаж, контент бэлтгэсэн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримтын бүрдэл дутуу бүртгэсэнтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант оны татварын тайлангаар тайлагнасан борлуулалтын дүн нь орлогын дэлгэрэнгүй тайлангийн дүнгээс 50.0 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэл хөтөлөлтийг стандарт, журам, зааврын дагуу хөтөлж, тайлагнаж байх.

2. Анхан шатны баримттай ажил гүйлгээг бүртгэл, тайлант илэрхийлээгүйтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Анхан шатны болон давж заалдах шатны шүүхийн магадлал, Дээд шүүхийн 2025 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 001/ШХТ2025/00940 тоот тогтоолоор Мэдээлэл, технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын гаргасан үндсэн нэхэмжлэхээс 2,329.7 сая төгрөгийг хариуцагч байгууллага (Ньютур сафарис ХХК)-иас төлүүлэхээр, Ньютур сафарис ХХК-аас гаргасан сөрөг нэхэмжлэхийн төлбөрт 3,116.9 сая төгрөгийг Мэдээлэл, технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ыг төлөхөөр шийдвэрлэснийг бүртгэж, тайлан тэнцэлд тусгаагүй байна.

Мэдээлэл, технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" гэж заасантай нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Дээд шүүхийн шийдвэрийг хангаж, ажил гүйлгээг санхүүгийн тайланд зөв дүнгээр бүртгэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Өмнөх онуудад үүссэн авлагыг бартераар буюу 20,000.00 мянган төгрөгийн бараа материалыар барагдуулсныг орлогоор бүртгэж тайлагнасан.	1	20,000.0	-	-	1	20,000.0	-	-	-	-
2	Харилцагч байгууллагаас авах авлагыг 52,800.0 мянган төгрөгийн хөрөнгөөр барагдуулсныг эрх бүхий байгууллагаас үндсэн хөрөнгөөр бүртгэх зөвшөөрөл олгосон, бүртгэл тайланд тайлагнаагүй байна.	1	52,800.0	1	52,800.0	-	-	1	52,800.0	-	-
3	Бараа материалын дэлгэрэнгүй тайлангийн үлдэгдэл нь санхүү байдлын тайлангийн бараа материалын үлдэгдэл дүнгээс 2,986.5 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн.	1	2,986.5	1	2,986.5	-	-	1	2,986.5	-	-
Дүн		3	75,786.5	2	55,786.5	1	20,000.0	3	75,786.5	-	-

/Мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн
			Тоо	Дүн	Тоо	Дүн		
Цалин болон ээлжийн амралтын хоногийг давхардуулж 2,564.2 мянган төгрөгийн илүү цалин бодож олгосон.	1	2,564.3	1	2,564.3	-	-	-	-
"JCI ASPAC-2025" олон улсын арга хэмжээнд зориулж виртуал аватар бүхий контентийг 3,800.0 мянган төгрөгөөр хийлгэн зардлаар бүртгэж тайлагнасан байна.	1	3,800.0	-	-	1	3,800.0	-	-
Тайлант онд барагдуулаагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 123,748.2 мянган төгрөгийн авлагыг үлдэгдэл байна.	1	123,748.2	-	-	1	123,748.2	-	-
Тайлант онд дотоод хэрэгцээнд зарцуулсан бараа материалын шаардах хуудсыг байгууллагын захирал хянан баталгаажуулж гарын үсэг зураагүй, 3,924.9 мянган төгрөгийн бараа материалыг шаардах хуудас бичилгүй зарцуулсан байна.	1	3,924.9	-	-	1	3,924.9	-	-
Тайлант оны эд хөрөнгийн тооллогын үр дүнг тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй, агуулахад байгаа бараа материалын тооллого хийгдсэн эсэх нь тодорхой бус, тооллогын тохируулгын тайлан хийгээгүй байна.	1	-	-	-	1	-	-	-
Нийслэлийн "Замын хөдөлгөөний удирдлагын төв" ОНӨТҮГ-нь тус паркийн 15 машины зогсоолын төлбөрийн орлогын 40%-ийг төвлөрүүлэх гэрээ байгуулсан, төлбөрийг төлөөгүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.	1	6,048.0	-	-	1	6,048.0	-	-

Мэдээлэл, технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Тайлант оны татварын тайлангаар тайлагнасан борлуулалтын дүн нь орлогын дэлгэрэнгүй тайлангийн дүнгээс 50,000.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	1	50,000.0	-	-	-	-	1	50,000.0
2025-03-31 ны өдрийн анхан шатны шүүхийн шийдвэр, 2025-06-09 ны өдрийн давж заалдах шатны шүүхийн магадлал, 2025-10-03 өдрийн 001/ШХТ2025/00940 тоот дээд шүүхийн тогтоолоор шалгагдаг байгууллагын гаргасан үндсэн нэхэмжлэхээс 2,329,68.1 мянган төгрөгийг хариуцагч байгууллагаар төлүүлэхээр, сөрөг нэхэмжлэхийн төлбөрт 3,116,882.4 мянган төгрөгийн үүргийн биелэлтийг шалгагдаг байгууллагаар хангахаар шийдвэрлэснийг тайлан тэнцэлд тусгаагүй байна.	1	787,200.3	-	-	-	-	1	787,200.3
Дүн	8	977,285.7	1	2,564.3	5	137,521.1	2	837,200.3

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Төлбөрийн акт		Албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын 1,210.8 сая төгрөгийн 70 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн, орлогын 93.3 сая төгрөгийн 6 гүйлгээ, зарлагын 104.7 сая төгрөгийн 8 гүйлгээг тус тус мэдээлээгүй байна.	1	198,085.7	-	-	-	1
Дүн	1	198,085.7	-	-	-	1
Нийт дүн	1	198,085.7	-	-	-	1



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 165/А0150061

Улаанбаатар хот

САГ-2026/56/КА-СТА-ТӨМГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нэр бүхий 2 ажилтанд цалин болон ээлжийн амралтын хоногийг давхардуулж 2,564,288.00 (Хоёр сая таван зуун жаран дөрвөн мянга хоёр зуун наян найман) төгрөгийн цалинг илүү бодож олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," гэж заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-т "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**


1. Илүү олгосон цалин 2,564,288.00 (Хоёр сая таван зуун жаран дөрвөн мянга хоёр зуун наян найман) төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт Мэдээлэл технологийн үндэсний паркийн захирал (Ж.Золзаяа), Санхүү, төлөвлөлтийн хэлтсийн дарга, Ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийн түр хавсран гүйцэтгэгч (Э.Зеданетуяа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХЯК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ

Д.НАСАНЖАРГАЛ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 765/АОК0061

Улаанбаатар хот

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗАР-ТӨЧӨГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"JCI ASPAC-2025" олон улсын арга хэмжээнд зориулж виртуал аватар бүхий контентийг 3,800,000.00 (Гурван сая найман зуун мянган) төгрөгөөр хийлгэж, тайлант хугацааны зардлаар бүртгэж тайлагнасан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4-т "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.4-д "Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, үр ашиггүй зарцуулалт гаргаж, контент бэлтгэсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мэдээлэл технологийн үндэсний паркийн захирал (Ж.Золзаяа), Санхүү, төлөвлөлтийн хэлтсийн дарга, Ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийн түр хавсран гүйцэтгэгч (Э.Эрдэнэтуяа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ

Д.НАСАНЖАРГАЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 766/20150061

Улаанбаатар хот

САГ-2026/56/МА-СТА-ТӨЧГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийслэлийн "Замын хөдөлгөөний удирдлагын төв" ОНӨТҮГ нь тус паркийн 15 машины зогсоолын төлбөрийн орлогын 40 хувийг төвлөрүүлэх гэрээ байгуулсан, төлбөрийг гэрээний дагуу төвлөрүүлээгүй, хоорондын тооцоо үүсгэж бүртгээгүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," "Тээврийн хэрэгслийн төлбөртэй зогсоолын үйл ажиллагаа эрхлэн явуулах гэрээ"-ний 2.4.12-т "төлбөртэй зогсоолын орлогыг тухайн сар бүрийн 25-ны өдөр Нийслэлийн төрийн сан банкны "Замын хөдөлгөөний удирдлагын төв", Авто зогсоолын төлбөрийн орлогын 100200000990 тоот дансанд шилжүүлэх" гэж заасантай тус тус нийцээгүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийг төвлөрүүлээгүй, хоорондын тооцоо үүсгэж бүртгээгүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мэдээлэл технологийн үндэсний паркийн захирал (Ж.Золзаяа), Санхүү, төлөвлөлтийн хэлтсийн дарга, Ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийн түр хавсран гүйцэтгэгч (Э.Эрдэнэтуяа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ

Д.НАСАНЖАРГАЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264730

Z:\Alban Shaardlaga\2026\03\16 SAG-42.Docx

1526181156



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 767/20150061

Улаанбаатар хот

СМ-2026/56/НА-СТА-ТӨЧГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд компанийн дотоод хэрэгцээнд зарцуулсан бараа материалын шаардах хуудсыг захирал хянан баталгаажуулж гарын үсэг зураагүй, 3,924,889.91 (Гурван сая есөн зуун хорин дөрвөн мянга найман зуун ерэн есөн төгрөг ерэн нэгэн мөнгө) төгрөгийн бараа материалыг шаардах хуудас бичилгүй зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бараа материалын зарцуулалтад тавих хяналт сул, анхан шатны баримтгүйгээр бараа материал зарлагадсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мэдээлэл технологийн үндэсний паркийн захирал (Ж.Золзаяа), Санхүү, төлөвлөлтийн хэлтсийн дарга, Ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийн түр хавсран гүйцэтгэгч (Э.Эрдэнэтуяа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН :

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ

Д.НАСАНЖАРГАЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-26-230

Z:\Alban Shaardlaga\20260316 SAG-42.Docx

1526181152



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 768/А0150061

Улаанбаатар хот

САГ-2026/56/НА-СТА-ТӨЧГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны эд хөрөнгийн тооллогын үр дүнг тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй, агуулахад байгаа бараа материалын тооллого хийгдсэн эсэх нь тодорхой бус, тооллогын тохируулгын тайлан хийгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 1-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө, үнэт цаас, мөнгөн хөрөнгийн тооллогыг дотоодын тооллого, улсын тооллого гэж хоёр хуваана.", 2-т "Эд хөрөнгийн тооллогын дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана.", 2 дугаар хэсгийн 1-д "үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жилд нэг удаа /12 дугаар сарын 01-нээс 31-ний дотор/", 72 дугаар зүйлийн 4-т "Тооллогын комисс дараах үүрэгтэй:", 4дүгээр хэсгийн 1-д "эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.2-т "хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй, иж бүрэн, үнэн зөв хийж, үр дүнг баталгаажуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мэдээлэл технологийн үндэсний паркийн захирал (Ж.Золзаяа), Санхүү, төлөвлөлтийн хэлтсийн дарга, Ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийн түр хавсран гүйцэтгэгч (Э.Эрдэнэтуяа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

9006109
ATA1602
ATA1511

Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ

Д.НАСАНЖАРГАЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-26 230

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-42.Docx

1526181154



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 769/00150061

Улаанбаатар хот

САГ-2026/56/НА-СТА-ТӨЧГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Мэдээлэл, технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх онуудад үүссэн тайлант онд барагдуулаагүй 123,738,192.74 (Нэг зуун хорин гурван сая долоон зуун гучин найман мянга нэг зуун ерэн хоёр төгрөг далан дөрвөн мөнгө) төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй, үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мэдээлэл технологийн үндэсний паркийн захирал (Ж.Золзаяа), Санхүү, төлөвлөлтийн хэлтсийн дарга, Ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийн түр хавсран гүйцэтгэгч (Э.Эрдэнэтүяа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН :

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ

Д.НАСАНЖАРГАЛ